

# **ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХЭСЭГЧЛЭН ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ<sup>1</sup>**

## **УДИРТГАЛ**

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.3-т “Хууль заавал хэрэгждэг, хүн бүрт эрх тэгш, алагчлалгүй, шударга үйлчилдэг, итгэл хүлээсэн хүний эрхийн мэдрэмжтэй, шударга ёсны засаглалыг бэхжүүлэх зарчмыг баримтлана” гэж, 5.4.1-д “Хуулийн байгууллагуудын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгож, иргэдэд чирэгдэлгүй, ялгаваргүй, тэгш, шударгаар үйлчлэх эрх зүйн орчинг цогцоор нь бүрдүүлнэ” гэж тус тус заасан байна.

ХЗДХЯ-наас ирүүлсэн 1-4/554 тоот албан бичигт үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн сайдаас өгсөн чиглэлийн дагуу шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбараас шалтгаалан 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгааг тогтоох үүднээс энэхүү хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийв.

Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийх энэхүү үнэлгээний зорилго нь тус хуулийн хэрэгжилтийн явц дахь хүндрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэн, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж, үнэлэлт дүгнэлт өгөх, зөвлөмж боловсруулахад оршино.

## **НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ**

Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хэсэгчлэн үнэлгээ хийх ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэсэн. Төлөвлөх үе шатанд дараахь ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

### **1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох**

Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний суурь эрх, халдашгүй байдлыг илүү баталгаажуулсан, олон улсын нийтийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагад нийцсэн урт хугацаанд тогтвортой үйлчлэх хуулийг батлан гаргах зүй ёсны шаардлага бий болж<sup>2</sup> улмаар Улсын Их Хурал Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг 2015 онд баталж, 2017 оноос эхлэн дагаж мөрдөх болсон билээ.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг дагаж мөрдөөд нэг жил гаруй хугацаа өнгөрч байна. Энэ хугацаанд Эрүүгийн хуулийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож,

<sup>1</sup> Энэхүү үнэлгээг ХЗҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн ухааны доктор П.Амаржаргал удирдан, Эрдэм шинжилгээний ажилтан Б.Ариунжаргал, О.Төрболд нар хамтран гүйцэтгэв.

<sup>2</sup> Эрүүгийн хуулийн төслийн үзэл баримтлал, ХЗЯ, УБ., 2013 он.

хэрэглэхэд хүндрэлтэй, эрх зүйн хийдэлтэй зохицуулалт нэлээдгүй байгааг салбарын эрдэмтэн, судлаач, шүүгч, прокурор, өмгөөлөгчид судлан үзэж өөр өөрийн байр суурийг илэрхийлсээр байна.<sup>3</sup>

Энэхүү маргаан бүхий зохицуулалтын нэг нь Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар буюу 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан зохицуулалт юм. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэгт “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй” гэж заасан нь практикт хэд хэдэн асуудлыг бий болгож байна.

Дээрх тайлбартай холбоотойгоор Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд бага хэмжээний хохирлоос<sup>4</sup> дээш хэмжээний хохирол учруулсан байхыг шаардахгүй байгаа юм. Уг асуудалд салбарын эрдэмтэн, судлаач, өмгөөлөгч, прокурор, шүүгчид өөр өөр байр суурийг илэрхийлж байна. Тухайлбал, зарим судлаачид<sup>5</sup> хуулийн дээрх зохицуулалт нь Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг буюу үндсэн бүрэлдэхүүндээ бага хэмжээнээс дээш хохирол шаардаж байгаа хэрнээ хүндрүүлэх бүрэлдэхүүндээ хохирол шаардахгүй байгаа нь гэмт хэрэг үйлдсэн хүний эрх зүйн байдлыг дордуулж, хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх эрхийг зөрчиж байна хэмээн үзэж байна.

Үүнтэй холбоотойгоор практикт маргаан дагуулаад байгаа Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэг болон Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан зохицуулалтад үнэлгээ хийх зайлшгүй шаардлага үүссэн гэж үзлээ.

Иймд энэхүү үнэлгээгээр дээр дурдсан зохицуулалтын хэрэгжилтийг үнэлэх болно.

## **1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох**

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн онцлог нь хорих ялыг биечлэн эдлүүлэх явдлыг багасгах, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхэд анхаарч, зорчих эрхийг хязгаарлах ял, хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ хэрэглэх, гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд насанд хүрсэн хүнээс ялгамжтай байдлаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх нөхцөлийг бүрдүүлж, ялын агуулга хэлбэрийг шинэчлэн тодорхойлж, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх институтыг тусгасан явдал юм.<sup>6</sup> Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн зохицуулалт нь

---

<sup>3</sup> Тухайлбал, судлаач Г.Ганбаатар “Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл дэх тайлбарт хийсэн дүн шинжилгээ” нийтлэл, судлаач Д.Нямбатын Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан “Хулгайлах” гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн үр нөлөөнд татгалзуулах онол (deterrence theory)-ын үүднээс хийсэн дүн шинжилгээ гэх мэт.

<sup>4</sup> Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлийн 4.3 дахь заалт “бага хэмжээний хохирол” гэж гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс доош хэмжээ

<sup>5</sup> Энэ талаар судлаач Г.Ганбаатар, Ж.Эрдэнэбулган, нар “Эрүүгийн хуулийн шинэчлэлийн тухай цөөн үг” нийтлэлдээ, судлаач Г.Ганбаатар “Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл дэх тайлбарт хийсэн дүн шинжилгээ” нийтлэлдээ, судлаач Б.Ганболд “Хулгайлах гэмт хэрэг (Хуулийн амин сүнсний хулгай)” нийтлэлдээ тус тус дурдаж өгсөн байна.

<sup>6</sup> Сургагч багш нарт зориулсан гарын авлага, ХЗДХЯ, УБ., 2017 он, 4 дэх тал.

дээрх онцлог шинжийг хангасан эсэх болоод уг зохицуулалтын эерэг, сөрөг талыг судалж, хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийхээр судалгааны хүрээг тогтоосон.

### 1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу Эрүүгийн хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран дараахь хоёр шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

1. Зорилгод хүрсэн түвшин;
2. Практикт нийцэж байгаа байдал;

#### 1.3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Эрүүгийн хуулийн 1.1 дүгээр зүйлд энэ хуулийн зорилгыг “Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд оршино” хэмээн тодорхойлжээ.

Үүнээс үзвэл, Эрүүгийн хуулийн үндсэн зорилгын нэг нь хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон харилцааг зохицуулах явдал болох нь харагдаж байна. Иймд энэхүү үнэлгээний шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дээр дурдсан зорилгыг хангахтай холбогдуулан тусгасан зүйл, заалтын нэг болох Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар болон 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан зохицуулалтыг сонгож “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлгээг хийлээ. Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

#### **Хүснэгт 1. Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалтууд**

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1	17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг	<p>2.Энэ гэмт хэргийг:</p> <p>2.1.хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч;</p> <p>2.2.түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг хулгайлж;</p> <p>2.3.ноцтой хохирол учруулж, их хэмжээний эд хөрөнгийг хулгайлж;</p> <p>2.4.учрах саадыг арилгах зорилгоор зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж, машин механизм ашиглаж үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>3.Энэ гэмт хэргийг:</p> <p>3.1.байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон;</p> <p>3.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>Тайлбар: -Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй.</p>

### 1.3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Энэхүү шалгуур үзүүлэлт нь тухайн хууль тогтоомжийн зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг, сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байгаа эсэхийг тодорхойлоход чиглэгддэг.

Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар нь Эрүүгийн хуулийн тулгамдаж буй асуудлуудын нэгд зүй ёсоор тооцогдож байна. Учир нь энэхүү тайлбарт “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй” гэж заасан нь судлаачдын дунд ихээхэн маргаан дагуулсаар байна. Учир нь бага хэмжээний хохирол учруулж, Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийг үйлдсэн тохиолдолд ялын хувьд сонгох санкцгүйгээр 2-8 жилийн хорих, 5-12 жилийн хорих ял оногдуулахаар хуульчилсан нь энэ гэмт хэргийн улмаас бусдад бага хэмжээний хохирол учруулсан хүний хувьд эрх зүйн байдал нь дордож, хүлээлгэж буй эрүүгийн хариуцлага нь үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирохгүй байна гэж зарим судлаачид<sup>7</sup> үзэж байна.

Иймд судалгааны энэ хэсэгт “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар буюу маргаан бүхий тус хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан зохицуулалтыг сонгож, уг зүйл, заалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа байдал, түүний эерэг болон сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл, бэрхшээл байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон болно. Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

### Хүснэгт 2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1	17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг	2.Энэ гэмт хэргийг: 2.1.хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч; 2.2.түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг хулгайлж; 2.3.ноцтой хохирол учруулж, их хэмжээний эд хөрөнгийг хулгайлж; 2.4.учрах саадыг арилгах зорилгоор зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж, машин механизм ашиглаж үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 3.Энэ гэмт хэргийг: 3.1.байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон; 3.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

<sup>7</sup> Тухайлбал, судлаач Г.Ганбаатар, Б.Ганболд, Ж.Эрдэнэбулган гэх мэт. Эдгээр судлаачдын нийтлэл, бүтээлүүдийг энэхүү судалгаанд ашигласан болно.

		<p>Тайлбар: -Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй.</p>
--	--	--

#### 1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлэх болсон шалтгаан, үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан дор дурдсан харьцуулах хэлбэрүүдээс сонгоно. Үүнд:

- Байх ёстой болон одоо байгаа;
- Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойш;
- Хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш;
- Тохиолдол судлах.

Судалгааны явцад Эрүүгийн хуулиас сонгон авсан зохицуулалтыг өмнөх хууль тогтоомж дахь заалттай харьцуулан авч үзэх хэлбэрийг ашиглана.

#### 1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох

Шалгуур үзүүлэлтийг томъёолохдоо сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр Эрүүгийн хуулийн сонгон авсан хэсэгт тохируулан дараахь таамаглал дэвшүүлж, асуулт боловсрууллаа:

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

**Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1.** Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар зорилгодоо хүрсэн эсэх?

Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

**Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1.** Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

#### 1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор баримт бичиг, судалгааны тайлан, илтгэл, өгүүллийг унших, судлах, харьцуулалт хийх, прокурор, шүүгчидтэй уулзаж ярилцлага, анкетын судалгааны аргаар санал авах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн бөгөөд аргачлалын 3.7.3-т мэдээлэл цуглуулах дөрвөн аргыг тодорхойлсноос дараахь хоёр аргыг сонгон үнэлгээ хийх мэдээллийг цуглуулсан болно:

1. Байгаа мэдээллийг цуглуулж ашиглах;
2. Холбогдох субъектээс судалгаа авах.

Байгаа мэдээллийг цуглуулах хүрээнд: Эрүүгийн хууль, холбогдох ном сурах бичиг, гарын авлага, эмхэтгэл, өгүүлэл, илтгэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайланг цуглуулж, үнэлгээ хийхэд ашиглав.

Холбогдох субъектээс судалгаа авах хүрээнд: Эрүүгийн хуулийг хэрэгжүүлэх явцад тулгамдаж буй асуудлыг илрүүлэхийн тулд прокурор, шүүгчидтэй уулзаж, ярилцлага болон анкетын аргаар судалгаа авсан. Мөн холбогдох байгууллагаас үйл ажиллагааны тайлан, судалгаа, бусад мэдээллийг гаргуулан авч үнэлгээ хийхэд ашиглав.

### **ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ**

Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааны мэдээллийг цуглуулахдаа баримт бичгийн судалгаа, прокурор, шүүгчдээс анкетын судалгаа авч, ярилцлагын аргад тулгуурлаж энэхүү судалгааг гүйцэтгэв.

Баримт бичгийн судалгаа: Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ дор дурдсан хууль тогтоомж, дүрэм, журам, эрдэмтэн, судлаачдын эрдэм шинжилгээний бүтээлүүд, илтгэл, өгүүлэл, тайланг ашигласан болно. Үүнд:

#### **Хууль, эрх зүйн акт**

- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1992, №1;
- Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002, №5;
- Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2016, №7;
- Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоол.

#### **Судалгааны тайлан, эмхэтгэл**

- Монгол Улсын Эрүүгийн хуулийг шинэтгэх төслийн санал, ХЗЯ, 2010 он;
- УИХ-ын гишүүн О.Батнасангийн санаачилсан Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, 2017 он;
- Эрүүгийн хуулийн төслийн үзэл баримтлал, ХЗЯ, 2013 он;
- Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх танилцуулга, ХЗДХЯ, 2016 он;
- “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь” судалгааны үндсэн тайлан, ХЗҮХ, 2016 он;
- “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь” хавсралт тайлан, ХЗҮХ, 2016 он;
- Монгол Улсын Шүүхийн шүүн таслах ажиллагааны 2018 оны тайлан.

#### **Ном, сурах бичиг, гарын авлага**

- Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном -2016, МУГХУСА33, 2017 он;
- Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном -2017, МУГХУСА33, 2018 он
- Монгол Улсын 2002 ба 2015 оны Эрүүгийн хуулийн харьцуулсан судалгаа, МУИС-ХЗС, 2016 он;
- Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, 2010 он;
- С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй /Ерөнхий ба тусгай анги/, 2011 он;
- С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол – I боть, 2009 он;
- С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол /Ялын тухай сургаал/ - II боть, 2014 он;
- С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг (Анхны хэвлэл), 2007 он;
- Сургагч багш нарт зориулсан гарын авлага, ХЗДХЯ, 2017 он;
- Эрүүгийн эрх зүй гарын авлага, ХЗДХЯ, 2007 он.

### **Эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл**

- Г.Ганбаатар, Ж.Эрдэнэбулган, “Эрүүгийн хуулийн шинэчлэлийн тухай цөөн үг” нийтлэл, 2017 он;
- Б.Ганболд, Хулгайлах гэмт хэрэг (Хуулийн амин сүнсний хулгай), Шүүх эрх мэдэл сэтгүүл, №2 2018 он;
- Г.Ганбаатар, Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл дэх тайлбарт хийсэн дүн шинжилгээ, Шүүх эрх мэдэл сэтгүүл №2, 2018 он;
- Д.Нямбат, Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан “Хулгайлах” гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн үр нөлөөнд татгалзуулах онол (deterrenve theory)-ын үүднээс хийсэн дүн шинжилгээ;
- Б.Өнөрмаа, Г.Оюунболд, “Эрүүгийн хуулийн хэрэгжилт” нийтлэл, 2017 он.

### **Цахим эх сурвалж**

- Shuukh.mn, Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан;
- Prokuror.mn, Монгол Улсын Ерөнхий Прокурорын Газрын албан ёсны цахим хуудас;
- Judcouncil.mn, Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн албан ёсны цахим хуудас.

### **Холбогдох субъектээс авсан судалгаа**

Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн талаар прокурор, шүүгчдээс ярилцлагын болон анкетын аргаар судалгаа авсан.

Ярилцлагын арга: Эрүүгийн хуулийн холбогдох зүйл, заалтын хэрэгжилтийн бодит байдал, хууль хэрэглээнд тулгамдаж буй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг тодруулахаар прокурор, шүүгчдийн төлөөлөлтэй ярилцлага хийсэн.

Прокурор, шүүгчдээс бүрдсэн нийт 236-н хүнээс анкетын аргаар судалгаа авсан.

Судалгааны анхдагч мэдээллийг ярилцлагын болон анкетын судалгааны аргаар практикт ажиллаж буй прокурор, шүүгчдээс авсан тул илүү бодитой, үр дүнтэй байдлыг хангаж чадна гэж үзсэн болно.

### **ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ**

Үнэлэх үе шатанд Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар буюу маргаан бүхий 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан заалтад сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийсэн.

#### **3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал**

2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад Эрүүгийн хуулийн зорилтыг зорилго хэмээн өөрчилсөн бөгөөд гэмт халдлагаас хамгаалахаас гадна гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгыг давхар агуулахаар заасан.<sup>8</sup>

Эрүүгийн хуулийн зорилгыг “Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” хэмээн 1.1 дүгээр зүйлд заасан байна. Иймд уг хуулийн бүхий л зохицуулалт энэхүү үндсэн зорилгыг хангахад чиглэн үйлчлэх учиртай.

**Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1.** Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар зорилгодоо хүрсэн эсэх?

---

<sup>8</sup> Сургагч багш нарт зориулсан гарын авлага, ХЗДХЯ, УБ., 2017 он, 5 дахь тал.

### **Үнэлгээ:**

Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө гэдэгт Монгол Улсын Үндсэн хуулийн хоёрдугаар бүлэгт Монгол Улсын иргэнд баталгаатай эдлүүлэхээр заасан үндсэн эрх, эрх чөлөө хамаарна.<sup>9</sup>

Үндсэн хуульд заасан хүний эрхийг хамгаалах нэгэн баталгаа нь Эрүүгийн хууль бөгөөд Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний эрх, эрх чөлөөг хамгаалж, ямар үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцон эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг шийдвэрлэдэг. Энэ ч утгаараа Эрүүгийн хууль нь бусад хууль тогтоомжоос илүү хүний эрх, эрх чөлөөг хязгаарлаж байдаг хатуу хууль юм.

Тиймээс ч Эрүүгийн хууль нь хүний амьдрах эрх, аюулгүй байдал, амин эрх ашиг, үнэт зүйлсийн үндсэн бөгөөд онцгой хамгаалалт учир Эрүүгийн хуулийн шинэчлэлийн бодлого, зохицуулалт нь орчин цагийн эрх зүйн хөгжлийн түгээмэл хандлага, нийгмийн бодит амьдрал ахуйд нийцсэн, зөв оновчтой, гэмт хэргийн гаралтыг ихэсгэхгүй харин бууруулах буюу тодорхой түвшинд тогтоон барихад чиглэгдсэн, энэрэнгүй, эрх зүйн хийдэлгүй байх зэрэг “олон талт” шалгуур, шаардлагыг хангасан байх ёстой.<sup>10</sup>

2002 оны Эрүүгийн хуулийг баталснаас хойш цаг үеийн нөхцөл байдал, нийгмийн шаардлагаас шалтгаалан уг хуульд 13 удаа нэмэлт, өөрчлөлт оруулж улмаар Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулах шаардлагатай гэж салбарын олон эрдэмтэн, судлаачид үзсэнээр 2015 онд Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулсан.

Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулах болсон нь Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан үнэт зүйлсийг материаллаг хуулиар хамгаалахдаа гэмт хэрэг, зөрчлийн шинжийг ойлгомжтой, хэрэглэхэд хялбар байдлаар, өнөөгийн нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өөрчилж, томъёолохоос гадна шинээр хамгаалах шаардлагатай харилцаа, хүний эрх, эрх чөлөө, хүний халдашгүй байдлыг хамгаалах хууль эрх зүйн баталгаатай орчныг бүрдүүлэхэд<sup>11</sup> чиглэсэн.

Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний суурь эрх, халдашгүй байдлыг илүү баталгаажуулсан, олон улсын нийтийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагад нийцсэн урт хугацаанд тогтвортой үйлчлэх хуулийг батлан гаргах зүй ёсны шаардлага бий болж<sup>12</sup> улмаар Улсын Их Хурал Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг 2015 онд баталж, 2017 оноос эхлэн дагаж мөрдөх болсон. Шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль хэрэгжиж эхэлснээс хойш практикт маргаан дагуулаад буй асуудлын нэг нь 17.1 дүгээр зүйлд заасан “Хулгайлах” гэмт хэргийн тайлбар хэсэг юм. Уг тайлбарт “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй” гэж заажээ.

---

<sup>9</sup> Мөн тэнд.

<sup>10</sup> Г.Ганбаатар, Ж.Эрдэнэбулган, Эрүүгийн хуулийн шинэчлэлийн тухай цөөн үг нийтлэл, 2017 он.

<sup>11</sup> Эрүүгийн хуулийн төслийн үзэл баримтлал, ХЗЯ, УБ., 2013 он.

<sup>12</sup> Мөн тэнд.



Энэхүү тайлбарыг судлан үзвэл Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулахдаа анх Гэмт хэргийн тухай хуулийн төсөл нэртэйгээр боловсруулж, уг төсөлд өөрчлөлт орж явсаар Эрүүгийн хуулийн төсөл боловсруулагдсан бөгөөд уг төсөлд хорих ялын доод хэмжээг 7 хоног, хулгайлах гэмт хэргийн хохирлын хэмжээг хуульчилж өгөөгүй зэрэг одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хуулиас нэлээд ялгаатай зохицуулалтууд байсан. Тухайлбал 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр Эрүүгийн хуулинд хулгайлах гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүнийг “Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан...” гэж хуульчилж өгсөн. Улмаар хууль тогтоогч 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Дээрх өөрчлөлтийн талаар судлаач Г.Ганбаатар: “Хожуу боловч энэхүү өөрчлөлтөөр Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан зохицуулалтын ноцтой сөрөг үр дагаврыг анхаарч, саармагжуулахад чиглэсэн нэг алхам нь энэхүү зүйлд хийсэн хууль тогтоогчийн тайлбар юм. Гэвч тухайн тайлбарт “...Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй” гэсэн бичвэрийг нэмж хуульчилсан нь “нуухыг нь авах гээд нүдийг нь сохолсон”, “Нэг алхам урагшилж, хоёр алхам хойшилсон” утга агуулгын бодит илрэл болсон буюу ялимгүй алдсан иргэдийн ирээдүйг шоронд булшлах бодлого дүр эсгэн хэвээр үлдсэн байна.<sup>13</sup> хэмээн тодорхойлсон байна.

Ийнхүү шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн юм. Шинэ хууль хэрэгжиж эхэлсэн өдрөөс 2018 оны 6 дугаар сарын 1-ний өдрийн хооронд улсын хэмжээнд хулгайлах төрлийн нийт 35397 гомдол, мэдээлэл хүлээн авч, 8390 гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Энэхүү тоо баримтаас харвал 2002 оны Эрүүгийн хууль үйлчилж байх үед хулгайлах гэмт хэргийн гаралт жил ирэх бүр өсч байсан ба 2015 оны Эрүүгийн хуулийн хэрэгжих цаг хугацаанд мөн л өссөөр байгааг харуулж байна.<sup>14</sup>

Улсын хэмжээнд 2017 оны 7 дугаар сарын 1-нээс 2018 оны 6 дугаар сарын 30-ны хооронд нийт 1650 хүн хулгайлах гэмт хэрэгт холбогдон шалгагдсанаас 137 буюу 8.3 хувь нь эмэгтэй, 1513 буюу 91.7 хувь нь эрэгтэй, 199 буюу 12.1 хувь нь хүүхэд байна.<sup>15</sup>

Практикт өсвөр насны (14-17) 4-н хүүхэд дэлгүүрээс 110.000-н төгрөгийн талх, боорцог, чихэр гэх мэт хүнсний зүйл хулгайлсан үйлдэлдээ Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2.1-д заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцогдон хорих ялаар шийтгүүлсэн<sup>16</sup> энэхүү асуудлаас үүдэн УИХ-ын гишүүн О.Батнасан “Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”-ийг санаачлан боловсруулж, Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлгийн зарим хэсэгт 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан юм.

Гэсэн хэдий ч дээрх өөрчлөлтөөр зөвхөн өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зарим зохицуулалтад өөрчлөлт оруулснаас бусдаар Эрүүгийн хуулийн тусгай ангийн маргаан бүхий зохицуулалтуудад өнөөдрийг хүртэл нэмэлт өөрчлөлт оруулаагүй хүчин төгөлдөр үйлчилсээр байна.

---

<sup>13</sup> Г.Ганбаатар, Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл дэх тайлбарт хийсэн дүн шинжилгээ, Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2018 он, №2, 79-80 дахь тал.

<sup>14</sup> Д.Нямбат, Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан “Хулгайлах” гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн үр нөлөөнд татгалзуулах онол (deterrence theory)-ын үүднээс хийсэн дүн шинжилгээ

<sup>15</sup> Мөн тэнд.

<sup>16</sup> УИХ-ын гишүүн О.Батнасангийн санаачилсан Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал.

Маргаан бүхий Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн аутентик тайлбарыг судлаачид өөр өөрийн үзэл бодлоор тайлбарлаж байна. Тухайлбал, судлаач Г.Ганбаатар “Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл дэх тайлбарт хийсэн дүн шинжилгээ” нийтлэлдээ “...Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн аутентик тайлбар нь “Зорилго чиглэл, утга агуулга”-ын хувьд гагцхүү Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт шууд хамааралтайгаар хуульчлагдсан, тухайн хамаарах хэсгийн хэм хэмжээний хамт хүчин чадалтай байх хэдий боловч тухайн тайлбар дахь “...Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй” гэсэн бичвэрийг “тайлбар” гэж үзэх боломжгүй харин эсрэгээр тайлбарт хамаарахгүй өөр зохицуулалтыг тусгасан нь хуулийн тухайн зүйлийн хэсгүүд хооронд зөрчилдөөн үүсгэж, улмаар иргэдийг хуучин Эрүүгийн хуулиас илүүтэй шоронжуулахад чиглэсэн үзэл санааг агуулсан нь илэрхий байна” хэмээн үзжээ.

Эрх зүйн хэм хэмжээний албан ёсны тайлбар нь кейсийн тайлбар болон хэм хэмжээний тайлбар гэсэн хоёр төрөлтэй байна. Эрх зүйн хэм хэмжээний буюу норматив тайлбар нь аутентик тайлбар ба хууль зүйн тайлбарт /Улсын Дээд шүүхийн абстракт тайлбар/ хуваагдана. Тэрээр Аутентик тайлбарыг тодорхойлохдоо эрх зүйн хэм, хэмжээг батлан гаргасан байгууллагаас тайлбарласан тайлбар. Эрх зүйн хэм хэмжээний утга санааг шууд тайлбарлахад чиглэгдэх хийгээд тэдгээрийг хэрэглэж байгаа бүхэнд заавал биелүүлэх шинжийг агуулдаг.<sup>17</sup>

Дээрхээс үзвэл, Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан бол хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” хэмээн заасан байх бөгөөд дээрх зүйлийн тайлбар хэсэгт “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй” гэж зааж өгсөн нь ямар нэгэн салаа утгагүйгээр хохирлын хэмжээнээс үл хамааран 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн бол 2 жилээс 12 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан байна.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг хэрэгжүүлж эхэлснээс хойш Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2018 онд нийт 17734 хүн, 4 хуулийн этгээдэд холбогдох 14207 эрүүгийн хэрэг хүлээн авч 12551 хэрэг шийдвэрлэсэн бөгөөд анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг өмнөх оноос 42.0 хувиар өссөн байна.<sup>18</sup>

Харин 2002 оны Эрүүгийн хууль хэрэгжиж байх үед хулгайлах гэмт хэргийг шүүхээс шийдвэрлэж байсан тоон мэдээг харвал 2011 онд 1282, 2012 онд 1281, 2013 онд 1283, 2014 онд 1336, 2015 онд 1418<sup>19</sup>, 2016 онд 2002 оны Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлд зааснаар 995 хэрэг, 2015 оны Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлд зааснаар буюу 421 хэрэг нийт 1416 хэрэг шийдвэрлэсэн байна.<sup>20</sup>

<sup>17</sup> С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг (Анхны хэвлэл), УБ., 2007 он, 648 дахь тал.

<sup>18</sup> Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны 2018 оны тайлан.

Дэлгэрэнгүйг <http://www.judcouncil.mn/main/8465--2018-.html> үзнэ үү.

<sup>19</sup> Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном - 2016, УБ., 2017 он, 152 дахь тал.

<sup>20</sup> Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном - 2017, УБ., 2018 он, 82 дахь тал.

**Хүснэгт 3. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс хянан шийдвэрлэсэн хулгайлах гэмт хэргийн тоон мэдээ /2018 он/<sup>21</sup>**

Эрүүгийн хууль /2015 он/ 17.1 дүгээр зүйл					
Хянан шийдвэрлэсэн		Нийт	17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	17.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг
	Хэрэг	1553	778	775	20
	Холбогдогч	2049	958	1061	30

Дээрх графикаас үзвэл, 2018 онд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 12551 хэрэг хянан шийдвэрлэснээс Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлд заасан 1553 хэрэг хянан шийдвэрлэгдсэн нь нийт анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн гэмт хэргийн 12.4 хувийг эзэлж байна.

Харин давж заалдах шатны шүүх 2018 онд эрүүгийн 2166 хэрэг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 9.9 хувиар өссөн. Хяналтын шатны шүүх 2018 онд эрүүгийн 851 хэрэг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 92.6 хувиар тус тус өссөн байна.<sup>22</sup>

Өнгөрсөн онтой харьцуулбал, шүүхээр хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 42 хувиар, ял шийтгүүлэгчдийн тоо мөн 37.1 хувиар тус тус өссөн. Энэ нь шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж гэмт хэрэг тус бүрт ял оногдуулж, шийдвэрлэдэг болсонтой холбоотой бөгөөд 2018 онд эдгээр хууль бүтэн жилийн хугацаанд хэрэгжиж эхэлсэн анхны жил болсонтой холбоотойгоор хянан шийдвэрлэсэн хэрэг, ял шийтгүүлсэн хүний тоо өсөлттэй гарахад нөлөөлсөн байна.<sup>23</sup>

Өөрөөр хэлбэл, шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль хэрэгжиж эхэлснээр гэмт хэргийн гаралт, ял шийтгүүлж буй хүний тоо өссөн үзүүлэлттэй байна.

Үүнээс хулгайлах гэмт хэргийн тухайд дэлгэрүүлэн судлан үзэхэд анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн нийт хэргээс хулгайлах гэмт хэрэг 137 хэргээр буюу 9.7 хувиар өссөн бөгөөд ял шийтгүүлэгчдийн байдлаар нь авч үзвэл хулгайлах гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 18.6 хувиар өсжээ.<sup>24</sup>

Ийнхүү хулгайлах гэмт хэргийн гаралт, ял шийтгүүлж буй хүний тоо өсөж буй нь шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбартай хамаарал бүхий байж болох юм.

Учир нь шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд хулгайлах гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүн нь бусдын “хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар...” авсан үйлдэл байх бөгөөд энэхүү үйлдлийн улмаас бага хэмжээнээс<sup>25</sup> дээш буюу 300.000

<sup>21</sup> Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн тоон мэдээ.

<sup>22</sup> Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны 2018 оны тайлан.

Дэлгэрэнгүйг <http://www.judcouncil.mn/main/8465--2018-.html> үзнэ үү.

<sup>23</sup> Мөн тэнд.

<sup>24</sup> Мөн тэнд.

<sup>25</sup> Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлийн 4.3-т “бага хэмжээний хохирол гэж гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс доош хэмжээг”, мөн хуулийн 5.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар

төгрөгөөс дээш хэмжээний хохирол учруулсан бол энэ гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг агуулахаар хуульчилжээ.

Гэтэл энэ зүйлийн тайлбар хэсэгт “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй” гэж заасан байна. Дээрх тайлбараас үүдэн хулгайлах гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр бага хэмжээний хохирол учруулж үйлдсэн тохиолдолд ч эрүүгийн хариуцлага хүлээхээр болж байгаа юм.

Харин 2002 оны Эрүүгийн хуульд хулгайлах гэмт хэргийн улмаас бусдад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага хохирол учруулсан тохиолдолд эрүүгийн хариуцлага шууд хүлээлгэх үндэслэл бүхий зохицуулалт байхгүй байсан юм. Хулгайлах гэмт хэргийн тухайд 2002 болон 2015 оны Эрүүгийн хуулийн зохицуулалтыг харьцуулан үзвэл:

**Хүснэгт 4. 2002 болон 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан “Хулгайлах” гэмт хэргийн зохицуулалт, түүний харьцуулалт**

№	2002 оны Эрүүгийн хууль	2015 оны Эрүүгийн хууль
1	<p>145 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг хулгайлах</p> <p>145.1. Бусдын эд хөрөнгийг хулгайлсны улмаас бага бус хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.</p> <p>145.2. Энэ гэмт хэргийг давтан бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, машин механизм, тусгайлан бэлтгэсэн багаж хэрэгсэл хэрэглэж буюу орон байр, агуулах саванд нэвтэрч үйлдсэн, энэ хэргийн улмаас үлэмж хэмжээний хохирол учирсан, олон тооны мал хулгайлсан бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>	<p>Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйл. Хулгайлах</p> <p>1. Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан бол хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>2. Энэ гэмт хэргийг:</p> <p>2.1. хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч;</p> <p>2.2. түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг хулгайлж;</p>

“...нэг нэгж нь нэг мянган төгрөгтэй тэнцүү байна. Өөрөөр хэлбэл, бага хэмжээний хохирол нь 300.000 төгрөг бөгөөд Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцон эрүүгийн хариуцлага хүлээлгэх нэг үндэслэл нь 300.000 төгрөгөөс дээш хэмжээний хохирол учруулсан байхыг шаардаж байгаа юм.

<p>145.3.Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн, эсхүл энэ хэргийн улмаас хохирогчийг амьдралын эх үүсвэрээс нь салгасан буюу их хэмжээний хохирол учирсан, түүнчлэн гамшгийг далимдуулж үйлдсэн бол эд хөрөнгийг хурааж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>145.4.Энэ хэргийг булаах, дээрэмдэх, уулгалан довтлох гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд, түүнчлэн онц аюултай гэмт хэрэгтэн, гэмт бүлэглэл үйлдсэн, энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хурааж, арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>	<p>2.3.ноцтой хохирол учруулж, их хэмжээний эд хөрөнгийг хулгайлж;</p> <p>2.4.учрах саадыг арилгах зорилгоор зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж, машин механизм ашиглаж үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>3.Энэ гэмт хэргийг:</p> <p>3.1.байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон;</p> <p>3.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>Тайлбар: -Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй.</p>
---	---

1. 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар хөдөлмөрийн харилцаанд хэрэглэдэг "хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ" гэдэг ойлголтыг Эрүүгийн хуульд тусгасан байсныг халж гэмт хэргийн ангилалт, учирсан хохирлын хэмжээг бодитой тогтоох, торгуулийн ял хэмжээг тогтвортой байлгах үүднээс Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар "нэгж" гэсэн хэмжигдэхүүнийг шинээр оруулж ирсэн. Учир нь 2002 оны Эрүүгийн хуулиар хөдөлмөр, нийгмийн зөвшилцлийн гурван талт Үндэсний хорооны шийдвэрээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ өөрчлөгдөхөд<sup>26</sup> эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байсан зарим хэргүүд гэмт хэргийн шинжгүй болж, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх тохиолдол цөөнгүй байсан.

2. 2015 оны Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр хулгайлах гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах эрүүгийн хариуцлагын төрөл нь дан ганц хорих ял байгаа бол 2002 оны Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.1, 145.2, 145.3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах ял нь сонгох санкцтай, 145.4 дэх хэсэгт заасан онц хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй гэмт хэрэгт сонгох санкцгүйгээр хорих ял оногдуулахаар хуульчилсан байжээ.

3. 2002 оны Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлд заасан "Бусдын эд хөрөнгийг хулгайлах" гэмт хэрэг нь үндсэн болон хүндрүүлэх бүрэлдэхүүндээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэхүйц буюу түүнээс дээш хэмжээний хохирол учруулсан тохиолдолд хулгайлах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцон ял оногдуулдаг байсан бол 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдсэн тохиолдолд 300.000 төгрөгөөс дээш хэмжээний хохирол учруулсан, харин

<sup>26</sup> Манай улсад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь 2000 оноос хойш нийт 13 удаа өөрчлөгдсөн.

хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр дээрх гэмт хэргийг үйлдсэн тохиолдол хохирол шаардахгүй байдлаар хуульчилснаараа өмнөх хуулиас нэлээд ялгаатай зохицуулалт болсон байна.

Түүнчлэн, шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбараас хамааран Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж бусдад бага хэмжээний хохирол учруулсан хүнд оногдуулах хорих ял нь Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлд "...тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна" гэж заасан шударга ёсны зарчимтай нийцэхгүй байгаа нь харагдаж байна. Үүнийг жишээгээр авч үзвэл:

**Тохиолдол 1.**

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 110 дугаар тогтоолтой иргэн Л.Б-д холбогдох эрүүгийн хэргийн талаар:<sup>27</sup>

Шүүгдэгч Л.Б нь 2018 оны 06 дугаар сарын 08-ны шөнө 23 цаг 30 минутын орчим Замын-Үүд сум 2 дугаар багт оршин суух иргэн Д.Э-н байнга амьдрах орон байранд нэвтэрч 1 ширхэг цайны халуун сав, 7.5 литр сарлагийн сүү, 5 кг үхрийн мах зэргийг хулгайлж 51.250 төгрөгийн бага хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт холбогдсон бөгөөд шүүхээс Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн 1.3-т заасныг журамлан, мөн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 2.1 дэх заалтад зааснаар шүүгдэгч Л.Б-д 1 /нэг/ жилийн хугацаагаар хорих ял оногдуулсан байна.

**Тохиолдол 2.**

Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүхийн 2019 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 09 дүгээр тогтоолтой иргэн Ш.С-д холбогдох эрүүгийн хэргийн талаар:<sup>28</sup>

Шүүгдэгч Ш.С нь 2018 оны 12 дугаар сарын 09-ний өдөр Өмнөговь аймгийн Цогтцэций сумын төвд үйл ажиллагаа явуулдаг Цэцгэн бууз цайны газраас иргэн М.Л-ийн гар цүнхийг хулгайлж бусдад 1.660.000 төгрөгийн хохирол учруулсан гэмт хэрэгт холбогджээ.

Шүүхээс Ш.С-г хулгайлах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцон, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Ш.С-д хорих ял оногдуулахгүйгээр 1 /нэг/ жил 6 /зургаа/-н сарын хугацаагаар тэнссэн байна.

Дээрх 2 тохиолдолд шүүхээс ялгамжтай байдлаар ял оногдуулсан байх бөгөөд эхний тохиолдолд Л.Б нь Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлд заасан "Хулгайлах" гэмт хэргийг хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй буюу хүн байнга амьдрах зориулалттай орон байранд нэвтэрч үйлдэн, 51.250 төгрөгийн хохирол учруулж улмаар 1 жил хорих ялаар шийтгүүлсэн бол хоёр дахь тохиолдолд цайны газраас Ш.С нь иргэн М.Л-ийн гар цүнхийг хулгайлж, 1.660.000 төгрөгийн хохирол учруулсан гэх хэрэгт шүүхээс хорих ял оногдуулахгүйгээр нэг жил зургаан сарын хугацаагаар тэнссэн байна.

Өөрөөр хэлбэл, учруулсан хохирлын хэмжээний хувьд хорих ял шийтгүүлсэн Л.Б нь 51.250 төгрөг буюу бага хэмжээний хохирол, хорих ял оногдуулахгүйгээр тэнсэгдсэн Ш.С нь 1.660.000 төгрөгийн хохирлыг бусдад учруулсан байна.

Товчхондоо хохирлын хэмжээ их байх тусмаа тухайн хүнд оногдуулах ялын хэмжээ нэмэгдэх нь зүйн хэрэг. Гэтэл бусдад 51.250 төгрөгийн хохирол учруулсныхаа төлөө 1 жил чөлөөгөө хасуулан эрүүгийн хариуцлагын хамгийн хүнд төрөл болох хорих ялаар шийтгүүлж байгаа нь Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлд заасан "Шударга ёсны зарчим"-д нийцэж буй эсэх нь эргэлзээтэй юм. Түүнчлэн, дээрх хоёр тохиолдол нь гэмт хэргийн ангиллын хувьд ч эрс ялгаатай байна.

<sup>27</sup> Дэлгэрэнгүйг <http://new.shuukh.mn/eruanhan/25274/view> үзнэ үү.

<sup>28</sup> Дэлгэрэнгүйг <http://new.shuukh.mn/eruanhan/28027/view> үзнэ үү.

Гэмт хэрэг бүрт нийгэмд аюултай байдлын шинж чанар, хэр хэмжээ оногдуулж болох ялын хүнд, хөнгөн зэрэг шалгууруудыг харгалзан нийт гэмт хэргүүдийг тодорхой төрөлд хуваахыг ангилалт гэнэ.<sup>29</sup>

Гэмт хэргийн ангилал нь гэмт хэргийг нийгмийн хор аюул, шинж чанараар нь ангилахын зэрэгцээ хууль зүйн үр дагаврыг ангиллаас нь хамааран ялгамжтайгаар тогтоох, эрүүгийн хариуцлагыг оновчтой тодорхойлоход ач холбогдолтой төдийгүй хууль зүйн техникийн хувьд ерөнхий ангид заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, тэнсэх, хорих ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэхэд чухал ач холбогдолтой тул гэмт хэргийг хөнгөн, хүнд гэсэн хоёр ангилалтай байхаар тусгасан.<sup>30</sup>

Дээрх тохиолдолд 51.250 төгрөгийн хохирол бусдад учруулсан хүний үйлдсэн хулгайлах гэмт хэрэг нь гэмт хэргийн ангиллын хувьд хүнд гэмт хэрэгт хамаарна. Харин 1.660.000 төгрөгийн хохирол учруулсан хүний үйлдсэн хулгайлах гэмт хэрэг нь хөнгөн гэмт хэрэгт хамаарч байна.

Нөгөөтээгүүр хууль тогтоогч Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт хулгайлах гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнийг хуульчлан өгсөн. Тухайлбал, дээрх 2 тохиолдолд Л.Б нь хүн байнга амьдрах зориулалттай орон байранд нэвтэрч эд зүйл хулгайлсан учир хүндрүүлэн авч үзэж буй нь зүйн хэрэг боловч хохирлын хэмжээ нь 51.250 төгрөг байгаа нь хулгайлах гэмт хэргийнхээ үндсэн бүрэлдэхүүнийг хангаагүй (17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэгт тооцохгүй) байхад хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр хулгайлах гэмт хэрэг үйлдсэн учраас бага хэмжээний хохирол учруулсан ч хүндрүүлэн зүйлчилж байгаа нь ерөөсгөл юм.

Учир нь эрүүгийн эрх зүйд гэмт хэргийн бүрэлдэхүүнийг үндсэн, хүндрүүлэх, онц хүндрүүлэх зэргээр тайлбарлан хэрэглэж ирсэн байдаг ба үндсэн бүрэлдэхүүний шинжгүй нөхцөлд дараахь хүндрүүлэх болон онц хүндрүүлэх бүрэлдэхүүний шинж бий болохгүй гэсэн үзэл хэвшин тогтсон ойлголт.<sup>31</sup>

Гэтэл шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлд заасан “Хулгайлах” гэмт хэргийн тайлбар нь дээрх ойлголттой зөрчилдөж байна.

Хуулийн энэхүү зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хамгаалахад чиглэж буй хэдий ч Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр бага хэмжээний хохирол учруулж хулгайлах гэмт хэрэг үйлдсэн хүнд ялгамжтай байдлаар хандаж, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, учруулсан хохирлыг үл харгалзаж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх зохицуулалтад нийцсэн эсэх нь эргэлзээ төрүүлэхүйц байна.

<sup>29</sup> С.Жанцан, Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол I боть, УБ., 2009 он, 206 дахь тал.

<sup>30</sup> ХЗДХЯ-аас гаргасан Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх танилцуулга.

<sup>31</sup> Б.Ганболд, Хулгайлах гэмт хэрэг (Хуулийн амин сүнсний хулгай), Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2018 он, №2, 61 дэх тал.

Мөн шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн зорилго нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, бууруулахад чиглэсэн бөгөөд энэ хууль хэрэгжиж эхэлснээс хойш хулгайлах төрлийн гэмт хэргийн гаралт, гэмт хэрэгт холбогдож ял шийтгүүлж буй хүний тоо ч мөн өссөн үзүүлэлттэй<sup>32</sup> байна. Иймд Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар зорилгодоо бүрэн хүрээгүй хэмээн үзэж байна.

### **3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд**

**Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1.** Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйл. Хулгайлах

2.Энэ гэмт хэргийг:

2.1.хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч;

2.2.түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг хулгайлж;

2.3.ноцтой хохирол учруулж, их хэмжээний эд хөрөнгийг хулгайлж;

2.4.учрах саадыг арилгах зорилгоор зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж, машин механизм ашиглаж үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг:

3.1.байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон;

3.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: -Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй.

#### **Үнэлгээ:**

Эрүүгийн хууль нь хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулж, улс үндэстний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг сахин хангах чиг үүрэг бүхий суурь хууль болохын хувьд эрх зүйн шинэтгэл, олон нийтийн анхаарлын төвд байнга байдаг.

Эрүүгийн хууль тогтвортой удаан хугацаанд мөрдөгдөж байх явдал чухал боловч уг хуулийн хэрэгжилт, үр нөлөө, нийгмийн эрэлт шаардлагад нийцэж байгаа эсэхэд тогтмол хяналт шинжилгээ хийж, хэрэв нийцэхгүй зүйл байвал түүнийг шинэчлэх, өөрчлөх арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлж байх нь зүйтэй.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг дагаж мөрдөөд жил гаруй хугацаа өнгөрч байна. Энэ хугацаанд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн алдаа, зөрчил, эрх зүйн хийдэл бүхий зохицуулалтуудыг практикт ажиллаж буй шүүгч, прокурор, өмгөөлөгч, салбарын эрдэмтэн, судлаач судалж, засаж сайжруулбал зохих асуудлын талаар<sup>33</sup> өөр өөрийн байр суурийг илэрхийлсээр байгаа билээ.

Маргаан бүхий энэхүү асуудлын талаар практикт ажиллаж буй прокурор, шүүгчдийн саналыг авснаар судалгааны үр дүн илүү бодитой гарна гэж үзсэний үндсэн дээр 78

<sup>32</sup> Тоон мэдээг үнэлгээний тайлангийн 12 дахь талаас дэлгэрүүлж үзнэ үү.


<sup>33</sup> Тухайлбал, Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйл, 6.7 дугаар зүйл, 7.1 дүгээр зүйл, мөн хуулийн 13.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг гэх мэт.



прокурор, 158 шүүгч, нийт 236 хүнээс анкетын аргаар судалгаа авч үр дүнг боловсруулсан болно.

Анкетын судалгааны үр дүнгээр:<sup>34</sup>

**График 1. Судалгаанд хамрагдсан байдал**



Нийт 236 оролцогч анкетын судалгаанд хамрагдсанаас шүүгч 158 буюу 67 хувийг, прокурор 78 буюу 33 хувийг тус тус эзэлж байна.

Анкетын судалгаагаар тавигдсан Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэг байх шаардлагатай юу? гэсэн асуултад судалгаанд хамрагдсан нийт оролцогчдын **72.5 хувь** нь шаардлагатай хэмээн хариулсан байна.

Мөн Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт хохирлын хэмжээг тусгаж өгөх шаардлагатай юу? гэсэн асуултад шаардлагатай гэж **83.9 хувь** нь хариулсан байна.

Дээрх 2 асуултын үр дүнгээс харвал Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар хэсгийг бүхэлд нь хүчингүй болгох нь буруу. Харин тодорхой хэсэг буюу "...Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй" гэснийг тайлбар хэсгээс хасах нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүрч болох юм.

Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн хүн тэр дундаа хулгайлах гэмт хэрэг үйлдэж бусдад бага хэмжээний хохирол учруулсан тохиолдолд оногдуулах ялын хэмжээ гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанарт тохирч байна уу? гэсэн асуултад тохирч байна гэж **8.5 хувь** нь, тохирохгүй байна гэж **51.7 хувь** нь, ялын төрлийг нэмж, сонголттой болгосноор тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанараас хамааруулан тохирох ялыг оногдуулах боломжтой гэж **39.8 хувь** нь хариулсан байна. Энэхүү асуултын хариултыг бататгах зорилгоор Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт ялын төрлийг нэмж хуульчлах шаардлагатай юу? гэсэн асуултад шаардлагатай гэж 72 хувь, шаардлагагүй гэж 28 хувь нь хариулсан байна.

Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж бусдад бага хэмжээний хохирол учруулсны улмаас дээрх гэмт хэрэгт гэм буруутайд тооцогдож хорих ял эдэлж буй хүмүүсийн хорих ялын хэмжээ тухайн гэмт хэргийнхээ нийгмийн аюулын шинж чанарт тохирохгүй байна гэж судалгаанд оролцогчдын олонхи нь үзэж байна. Тиймээс энэхүү гэмт хэрэгт оногдуулж буй ялын төрлийг нэмэгдүүлэх шаардлагатай хэмээн хариулсан гэж үзэж болох юм.

Түүнчлэн, практикт дээрх төрлийн гэмт хэргийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч тухайн этгээдийн хувийн байдал, үйлдэл, эс үйлдэхүйн

<sup>34</sup> Дэлгэрэнгүйг хавсралт 1, 2, 3-аас үзнэ үү.

нийгмийн аюулын хэр хэмжээ нь энэ хуулиар хамгаалагдсан эрх ашигт бодит хохирол, хор уршиг учруулаагүй үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцохгүй” гэж заасныг үндэслэн шийдвэрлэж буй тохиолдол цөөнгүй байна. Үүнийг жишээгээр авч үзвэл:

### **Тохиолдол 3.**

Увс аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 35 дугаар шийтгэх тогтоол<sup>35</sup>, Увс аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны 2018 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 14 дүгээр магадлал<sup>36</sup>, Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүхийн 299 дүгээр тогтоолтой Т.О, Б.Х нарт холбогдох эрүүгийн хэргийн талаар:<sup>37</sup>

Т.О, Б.Х нар нь 2017 оны 12 дугаар сарын 8-ны шөнө Увс аймгийн Улаангом сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрээс тоёота аллион загварын саарал өнгийн 06-83 УВХ улсын дугаартай автомашин ашиглаж хохирогч Ц.А-гийн эзэмшлийн ногооны талбайн 20 метр урттай төмөр тор хулгайлж нийт 90.000 төгрөгийн хохирол учруулсан бөгөөд гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлсөн бөгөөд анхан шатны шүүхээс Б.Х, Т.О нарт тус бүрт нь нэг жилийн хорих ял оногдуулсан.

Давж заалдах шатны шүүхээс энэхүү хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасан.

Харин давж заалдах шатны шүүх уг хэргийг хянан хэлэлцээд “шүүгдэгч Т.О, Б.Х нарын ногооны талбайн 20 метр урттай төмөр тор хулгайлж учирсан 90.000 төгрөгийн хохирлыг нь Эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх ашигт бодитой хохирол учирсан гэж дүгнэхээргүй байх тул Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан үйлдлийг гэмт хэрэгт тооцох үндэслэлгүй гэсэн прокурорын дүгнэлтийг хүлээн авахаар тогтов” гэжээ. Ийнхүү хяналтын шатны шүүхээс ЭХХШТХ-ийн 34.19 дүгээр зүйлийн 1.1-д зааснаар хэрэгсэхгүй болгож, цагаатгасан байна.

Дээрх тохиолдолд анхан шатны шүүхээс машин механизм нь ашиглаж хулгайлах гэмт хэрэг үйлдэж бусдад 90.000 төгрөгийн хохирол учруулсан Т.О, Б.Х нарын үйлдэлд нэг жилийн хорих ял оногдуулсан бөгөөд 90.000 төгрөгийн хохирол учруулж, хохирлоо нөхөн төлсөн ч эрх чөлөөгөө нэг жилийн хугацаагаар хязгаарлуулж байгаа нь тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээнд эрүүгийн хариуцлага тохирсон эсэх нь эргэлзээтэй.

Хорих ял гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь тогтоогдвол шүүх Эрүүгийн хуульд заасан хугацаанд эрх чөлөөг нь хязгаарлаж, олон нийтээс тусгаарлаж, тусгай дэглэм бүхий хорих анги, гянданд албадан байлгадаг төрийн албадлагын **хатуу цээрлэл** агуулсан арга хэмжээ<sup>38</sup> гэтэл 90.000 төгрөгийн хохирол бусдад учруулж, хорих ял эдэлнэ гэдэг нь хохирол болон нийгмийн аюулын хэр хэмжээндээ тохирох эсэх нь эргэлзээтэй байна.

Энэ байдлыг хяналтын шатны шүүхээс харгалзан үзэж Эрүүгийн хуулийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “...Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч тухайн этгээдийн хувийн байдал, үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын хэр хэмжээ нь энэ хуулиар хамгаалагдсан эрх ашигт бодит хохирол, хор уршиг учруулаагүй үйлдэл, эс үйлдэхгүйг гэмт хэрэгт тооцохгүй” гэж заасныг журамлан Т.О, Б.Х нарт холбогдох эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгон, цагаатгаж шийдвэрлэсэн байна.

Тэгвэл, Т.О, Б.Х нарын үйлдсэн хулгайлах гэмт хэргийг адил төсөөтэй хэргүүдийг практикт Эрүүгийн хуулийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасныг журамлан хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэж байгаа эсэхийг судлах зорилгоор анкетын судалгаагаар

<sup>35</sup> Дэлгэрэнгүйг <http://new.shuukh.mn/eruanhan/18434/view> үзнэ үү.

<sup>36</sup> Дэлгэрэнгүйг <http://new.shuukh.mn/eruudavah/5384/view> үзнэ үү.

<sup>37</sup> Дэлгэрэнгүйг <http://new.shuukh.mn/eruhyanalt/962/view> үзнэ үү.

<sup>38</sup> УДШ, Ханнс Зайделийн сан, “Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар”, 2010 он, 162-163 дахь тал.

Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж бусдад бага хэмжээний хохирол учруулсан тохиолдолд тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанарт тохируулан Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар тухайн үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй байх боломжтой юу? гэсэн асуулт тавихад:

*“Тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанараас хамааруулан гэмт хэрэгт тооцохгүй байх боломжтой”* гэж судалгаанд хамрагдсан нийт оролцогчдын **37.3 хувь** нь хариулсан бол *“Боломжгүй. Учир нь хууль тогтоогч 17.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэгт энэхүү гэмт хэрэгт хохирол шаардахгүй байхаар тодорхой байдлаар тусгасан”* гэж **62.7 хувь** нь хариулсан байна.

Мөн Та Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж бага хэмжээний хохирол бусдад учруулсан хэрэгт Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн гэмт хэрэгт тооцохгүй байдлаар хэрэг шийдвэрлэсэн тохиолдол байгаа юу? гэсэн асуултад судалгаанд хамрагдсан нийт оролцогчдын **13.1 хувь** нь тийм гэж, **86.9 хувь** нь үгүй гэж тус тус хариулсан байна.

Гэсэн хэдий ч дээрх асуултад хариулсан шүүгч, прокуроруудын хариулт нэлээд ялгамжтай байсан бөгөөд тухайлбал, прокуроруудын 32.1 хувь, шүүгчдийн 3.8 хувь нь дээрх асуултад тийм гэж хариулсан байна.

Дээрхээс дүгнэвэл, практикт прокурорын хяналтын шатанд Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж бага хэмжээний хохирол бусдад учруулсан хэрэгт Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн гэмт хэрэгт тооцохгүй байдлаар хэрэг шийдвэрлэж буй тохиолдолд шүүхээс илүү байна.

Анкетын судалгааны үр дүнг нягтлах зорилгоор Монгол Улсын шүүхийн шийдвэрийн shuukh.mn цахим сангаас 2019 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн байдлаар Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2.1 дэх заалтад зааснаар эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс хянан шийдвэрлэгдэж, тус санд байршуулсан нийт 724<sup>39</sup> хэргээс санамсаргүй түүврийн аргаар 200 хэрэг сонгон судалж, түүнээс Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2.1 дэх заалтад заасан хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр бусдад бага хэмжээний хохирол учруулж шүүхээс шийдвэрлэгдсэн хэргийг түүвэрлэн судалсан болно.

Санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан 200 хэргээс 30 хүнд холбогдох 27 хэрэг<sup>40</sup> нь Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2.1 дэх заалтад заасан хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр бусдад бага хэмжээний хохирол учруулж хулгайлах гэмт хэрэг үйлдсэн тохиолдол байв.

Энэхүү 30 хүнд холбогдох 27 эрүүгийн хэрэгт шүүхээс оногдуулсан ялыг судлан үзэхэд 1 хүнд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ, үлдсэн хүмүүст хорих ял оногдуулсан байна. Хорих ял шийтгүүлсэн 29 хүнд хамгийн багадаа 1 жилийн хорих ял, ихдээ 2 жил 1 сарын хорих ял оногдуулсан байна. Үүнийг дунджилж үзвэл ойролцоогоор 1 жил 3 сарын хорих ял оногдуулсан байна.

Дээрх 27 хэргийн хохирлын хэмжээг харвал, хамгийн бага нь 20.000 төгрөгийн, хамгийн их нь 300.000 төгрөгийн хохирол бусдад учруулсан байх бөгөөд хохирлын хэмжээ нь дундажаар 178.993 төгрөг байна.

---

<sup>39</sup> shuukh.mn (Сүүлд үзсэн огноо 2019.3.4.)

<sup>40</sup> Дэлгэрэнгүйг хавсралт 4-өөс үзнэ үү.

Гэмт хэрэг үйлдсэн хүний насны байдлын хувьд дээрх 30 хүнээс 9 хүний насны байдлыг шүүхийн шийдвэрт тусгалгүй орхигдуулсан байна. Үлдсэн 21 хүнээс хамгийн бага нь 18 настай, хамгийн өндөр нь 51 настай хүн байх бөгөөд гэмт хэрэг үйлдсэн хүний дундаж нас 34 байна.

Хулгайлах үйлдэл нь мөн чанартаа нэг үйлдэл бөгөөд үүнийг том, жижиг гэж хоёр хуваах нь шударга ёсны зарчимд харшилдаг. Шударга ёсны зарчмын хүрээнд авч үзвэл Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлийн хүндрүүлэх шинж болох "орон байранд нэвтэрсэн" хулгайлах үйлдэлд хохирол шаардахгүй атлаа, "нэвтрээгүй" үйлдэлд 300.000 төгрөгнөөс дээш хохирол шаардаж байгаа нь учир дутагдалтай юм.<sup>41</sup>

Практикт маргаан үүсгээд буй асуудлыг ерөнхийлөн авч үзвэл Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбарт "...Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй" гэсэн бичвэрийг хуульчилсан явдал юм.

Тайлбарын энэхүү хэсгийг судлаач Г.Ганбаатар "Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл дэх тайлбарт хийсэн дүн шинжилгээ" нийтлэлдээ "Монгол Улсын Үндсэн хуулийн "хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг эрхэмлэн дээдэлж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх" эрхэм зорилго, мөн тус хуулиар хамгаалсан үнэт зүйлс, шударга ёс Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын "хүнтэй ... хүнлэг бусаар харьцах буюу шийтгэхийг хориглосон" 7 дугаар зүйлийг зөрчсөн гэж үзэх үндэслэлийг бүрдүүлсэн<sup>42</sup> хэмээн дүгнэсэн байна.

Нөгөөтээгүүр, энэхүү тайлбарыг утгачилан ойлговол Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсгийн "энэ гэмт хэргийг..." гэдэг нь Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүний шинж бүрэн хангагдсан тухайн гэмт хэргийг л ойлгодог. Тийм ч учраас гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүний дараа харин хүндрүүлэх бүрэлдэхүүний өмнө нь " энэ гэмт хэргийг..." гэж Эрүүгийн хуулийн тухайн зүйлийн 2, 3 дахь (хэдэн хэсэгтэй ч байж болно) хэсэг болгон тусгайлан хуульчлан заадаг ба тус хэсгийн заалт болгож тус гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнийг нарийвчилсан, дэс дараалсан байдлаар зохицуулдаг.<sup>43</sup>

Дээрхээс дүгнэвэл, Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар хэсгийн "...Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй" гэж заасныг практикт хэрэгжүүлэхэд сөрөг нөлөө үүсгэж, хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр бусдад бага хэмжээний хохирол учруулж хулгайлах гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд 2-12 жилийн хорих ял оногдуулахаар хуульчилсан нь хорих ял эдлэх хүний тоог нэмэгдүүлэхээр байна гэж үзэж байна.

## **ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

### **4.1. ДҮГНЭЛТ**

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг дагаж мөрдсөнөөс хойш жил гаруй хугацаа өнгөрч байна. Энэ хугацаанд эрх зүйн хийдэлтэй зохицуулалт болон маргаан дагуулж буй

---

<sup>41</sup>Б.Өнөрмаа, Г.Оюунболд, "Эрүүгийн хуулийн хэрэгжилт" нийтлэл, 2017 он. Дэлгэрэнгүйг <http://www.prokuror.mn/a/1946> үзнэ үү. (Сүүлд үзсэн: 2019.2.21)

<sup>42</sup> Г.Ганбаатар, Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл дэх тайлбарт хийсэн дүн шинжилгээ, Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2018 он, №2, 80 дахь тал.

<sup>43</sup> Мөн тэнд.

заалтуудыг хэрхэн засаж, сайжруулах талаар олон талын сургалт, хэлэлцүүлэг<sup>44</sup>, судалгаанууд хийгдсээр байгаа билээ. Энэ хүрээнд Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар буюу 17.1 дүгээр зүйлийн 2,3 дахь хэсгийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, дараахь дүгнэлтэд хүрч байна. Үүнд:

1. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбарт "...Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй" гэж заасныг практикт хэрэгжүүлэхэд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Хамгийн түгээмэл байдлаар Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2.1 дэх хэсэгт заасан "... хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрсэн", мөн зүйлийн 2.3 дахь хэсэгт заасан "учрах саадыг арилгах зорилгоор зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж, машин механизм ашиглаж үйлдсэн" хэргүүдэд хохирлын хэмжээ нь 300.000 төгрөг хүрээгүй хэргүүд байсан боловч шүүхээс эдгээр хэрэгт хуульд заасан үндэслэл журмын дагуу хорих ял оногдуулан шийдвэрлэж байна.

Өөрөөр хэлбэл, хулгайлах гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр үйлдэж бусдад 1-300.000 төгрөгийн хохирол учруулсан үйлдэлдээ гэмт хэрэг үйлдсэн хүн 2-12 жилийн хорих ял шийтгүүлэхээр хуульчилжээ.

Энэ нь гэмт хэрэг үйлдсэн хүний эрх зүйн байдлыг дордуулахын зэрэгцээ Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлд заасан "Шударга ёсны зарчим"-тай зөрчилдөж байна хэмээн дүгнэж болох юм.

2. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт дан ганц хорих ял оногдуулахаар хуульчилсан нь тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, учруулсан хохирол зэрэг олон шалтгаан нөхцөлийг шүүх тал бүрээс нь бүрэн бодитой хянан шийдвэрлэж, гэмт хэрэг үйлдсэн хүнд тохирох ял шийтгэлийг оногдуулахад хязгаарлагдмал байдлыг бий болгож байна хэмээн үзэж болох юм.

Энэхүү судалгааны явцад шүүгч, прокуроруудаас анкетын аргаар судалгаа авахад энэ гэмт хэрэгт оногдуулах ялын төрлийг нэмж, сонголттой болгосноор тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанараас хамааруулан тохирох ялыг гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах боломжтой гэж нийт оролцогчдын 39.8 хувь нь хариулсан нь энэ гэмт хэрэгт оногдуулах ялын төрлийг нэмж хуульчлах боломжийг судлан үзэх шаардлагатай болохыг илэрхийлж байна.

#### **4.2. ЗӨВЛӨМЖ**

Судалгааны үр дүнд гарсан дүгнэлтэд тулгуурлан шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг гаргаж байна. Үүний тулд:

1. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар хэсгээс "...Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй" гэсэн хэсгийг хасах;

---

<sup>44</sup> Тухайлбал, УИХ-ын ХЗБХ, ХЗДХЯ-тай хамтран "Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх хэлэлцүүлэг", "Шүүхийн шийдвэр түүний хэрэглээ ач холбогдол" сэдэвт хэлэлцүүлэг, "Эрүүгийн хуулийн шинэтгэлийн үйл явц" сэдэвт хэлэлцүүлэг, "Хүний эрх, эрх чөлөөний хууль зүйн баталгаа - онол практикийн асуудал" олон улсын эрдэм шинжилгээний хурал гэх мэт.

2. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан ялын төрлийг нэмэх. Тухайлбал, арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ялыг нэмэх.<sup>45</sup>

---

<sup>45</sup> Практикт түгээмэл үйлдэгддэг гэмт хэргийн нэг болох Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлд заасан “Залилах” гэмт хэргийг хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр үйлдсэн тохиолдолд энэ хуулийн 17.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “...арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заасныг харгалзан үзэж дээрх саналыг гаргасан болно.

## ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

### Хууль, эрх зүйн акт

- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1992, №1;
- Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002, №5;
- Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2016, №7;
- Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоол.

### Судалгааны тайлан, эмхэтгэл

- Монгол Улсын Эрүүгийн хуулийг шинэтгэх төслийн санал, ХЗЯ, 2010 он;
- УИХ-ын гишүүн О.Батнасангийн санаачилсан Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, 2017 он;
- Эрүүгийн хуулийн төслийн үзэл баримтлал, ХЗЯ, 2013 он;
- Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх танилцуулга, ХЗДХЯ, 2016 он;
- “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь” судалгааны үндсэн тайлан, ХЗҮХ, 2016 он;
- “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь” хавсралт тайлан, ХЗҮХ, 2016 он;
- Монгол Улсын Шүүхийн шүүн таслах ажиллагааны 2018 оны тайлан.

### Ном, сурах бичиг, гарын авлага

- Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном -2016, МУГХУСА33, 2017 он;
- Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном -2017, МУГХУСА33, 2018 он
- Монгол Улсын 2002 ба 2015 оны Эрүүгийн хуулийн харьцуулсан судалгаа, МУИС-ХЗС, 2016 он;
- Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, 2010 он;
- С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй /Ерөнхий ба тусгай анги/, 2011 он;
- С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол – I боть, 2009 он;
- С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол /Ялын тухай сургаал/ - II боть, 2014 он;
- С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг (Анхны хэвлэл), 2007 он;
- Сургагч багш нарт зориулсан гарын авлага, ХЗДХЯ, 2017 он;
- Эрүүгийн эрх зүй гарын авлага, ХЗДХЯ, 2007 он.

### Эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл

- Г.Ганбаатар, Ж.Эрдэнэбулган, “Эрүүгийн хуулийн шинэчлэлийн тухай цөөн үг” нийтлэл, 2017 он;
- Б.Ганболд, Хулгайлах гэмт хэрэг (Хуулийн амин сүнсний хулгай), Шүүх эрх мэдэл сэтгүүл, №2 2018 он;
- Г.Ганбаатар, Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл дэх тайлбарт хийсэн дүн шинжилгээ, Шүүх эрх мэдэл сэтгүүл №2, 2018 он;
- Д.Нямбат, Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан “Хулгайлах” гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн үр нөлөөнд татгалзуулах онол (deterrenve theory)-ын үүднээс хийсэн дүн шинжилгээ;
- Б.Өнөрмаа, Г.Оюунболд, “Эрүүгийн хуулийн хэрэгжилт” нийтлэл, 2017 он.

### Цахим эх сурвалж

- [Shuukh.mn](http://Shuukh.mn), Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан;
- [Prokuror.mn](http://Prokuror.mn), Монгол Улсын Ерөнхий Прокурорын Газрын албан ёсны цахим хуудас;
- [Judcouncil.mn](http://Judcouncil.mn), Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн албан ёсны цахим хуудас.



**Анкетын судалгааны нийт үр дүн**

Судалгаанд оролцогч	Судалгаанд оролцогчдын тоо	Хувь
Шүүгч	158	67
Прокурор	78	33
Нийт	236	100

**Асуулт 1. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэг байх шаардлагатай юу?**

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Шаардлагатай.	171	72.5
2	Шаардлагагүй.	65	27.5
Нийт		236	100

**Асуулт 2. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт хохирлын хэмжээг тусгаж өгөх шаардлагатай юу?**

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Шаардлагатай.	198	83.9
2	Шаардлагагүй.	29	16.1
Нийт		236	100

**Асуулт 3. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн хүн тэр дундаа гэмт хэргийн улмаас бага хэмжээний хохирол бусдад учруулсан тохиолдолд оногдуулах ялын хэмжээ гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанарт тохирч байгаа эсэх?**

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Тийм	20	8.5
2	Үгүй	122	51.7
3	Ялын төрлийг нэмж, сонголттой болгосноор тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанараас хамааруулан тохирох ялыг оногдуулах боломжтой.	94	39.8
Нийт		236	100

**Асуулт 4. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт ялын төрлийг нэмэх шаардлагатай юу?**

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь

1	Шаардлагатай.	170	72
2	Шаардлагагүй.	66	28
Нийт		236	100

**Асуулт 5. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж бусдад бага хэмжээний хохирол учруулсан тохиолдолд тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанарт тохируулан Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар тухайн үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй байх боломжтой юу?**

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Боломжтой. Тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанараас хамааруулан гэмт хэрэгт тооцохгүй байх боломжтой.	88	37.3
2	Боломжгүй. Учир нь хууль тогтоогч 17.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэгт энэхүү гэмт хэрэгт хохирол шаардахгүй байхаар тодорхой байдлаар тусгасан.	148	62.7
Нийт		236	100

**Асуулт 6. Та Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж бага хэмжээний хохирол бусдад учруулсан хэрэгт Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн гэмт хэрэгт тооцохгүй байдлаар хэрэг шийдвэрлэсэн тохиолдол байгаа эсэх.**

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Тийм	31	13.1
2	Үгүй	205	86.9
Нийт		236	100

**Асуулт 7. Дээрхээс гадна Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийг практикт хэрэгжүүлэхэд тулгамдаж буй нөхцөл байдал байвал дурдана уу.**

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Хариулсан	113	47.9
2	Хариулаагүй	123	52.1
Нийт		236	100

**Асуулт 8. Танд Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлтэй холбоотой засаж сайжруулах ямар санал байна вэ?**

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь

1	Хариулсан	116	49.1
2	Хариулаагүй	120	50.9
Нийт		236	100

**Шүүгчдээс авсан анкетын судалгааны үр дүн**

№	Албан тушаал	Саналын тоо	Хувь
1	Хяналтын шатны шүүгч	0	0
2	Давж заалдах шатны шүүгч	44	27.8
3	Анхан шатны шүүгч	114	72.2
Нийт		158	100

**Асуулт 1. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэг байх шаардлагатай юу?**

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Шаардлагатай.	105	66.5
2	Шаардлагагүй.	53	33.5
Нийт		158	100

**Асуулт 2. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт хохирлын хэмжээг тусгаж өгөх шаардлагатай юу?**

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Шаардлагатай.	129	81.6
2	Шаардлагагүй.	29	18.4
Нийт		158	100

**Асуулт 3. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн хүн тэр дундаа гэмт хэргийн улмаас бага хэмжээний хохирол бусдад учруулсан тохиолдолд оногдуулах ялын хэмжээ гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанарт тохирч байгаа эсэх?**

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Тийм	16	10.1
2	Үгүй	77	48.7
3	Ялын төрлийг нэмж, сонголттой болгосноор тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанараас хамааруулан тохирох ялыг оногдуулах боломжтой.	65	41.2
Нийт		158	100

**Асуулт 4. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт ялын төрлийг нэмэх шаардлагатай юу?**

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Шаардлагатай.	115	72.8
2	Шаардлагагүй.	43	27.2
Нийт		158	100

**Асуулт 5. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж бусдад бага хэмжээний хохирол учруулсан тохиолдолд тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанарт тохируулан Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар тухайн үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй байх боломжтой юу?**

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Боломжтой. Тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанараас хамааруулан гэмт хэрэгт тооцохгүй байх боломжтой.	46	29.1
2	Боломжгүй. Учир нь хууль тогтоогч 17.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэгт энэхүү гэмт хэрэгт хохирол шаардахгүй байхаар тодорхой байдлаар тусгасан.	112	70.9
Нийт		158	100

**Асуулт 6. Та Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж бага хэмжээний хохирол бусдад учруулсан хэрэгт Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн гэмт хэрэгт тооцохгүй байдлаар хэрэг шийдвэрлэсэн тохиолдол байгаа эсэх.**

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Тийм	6	3.8%
2	Үгүй	152	96.2%
Нийт		158	100%

**Асуулт 7. Дээрхээс гадна Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийг практикт хэрэгжүүлэхэд тулгамдаж буй нөхцөл байдал байвал дурдана уу.**

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Хариулсан	69	43.7%
2	Хариулаагүй	89	56.3%
Нийт		158	100%

**Асуулт 8. Танд Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлтэй холбоотой засаж сайжруулах ямар санал байна вэ?**

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Хариулсан	66	41.8%
2	Хариулаагүй	92	58.2%
Нийт		158	100%

**Прокуроруудаас авсан анкетын судалгааны үр дүн**

№	Албан тушаал	Саналын тоо	Хувь
1	Туслах прокурор	1	1.3
2	Ахлах прокурор	15	19.2
3	Хяналтын прокурор	62	79.5
Нийт		78	100

**Асуулт 1. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэг байх шаардлагатай юу?**

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Шаардлагатай.	66	84.6
2	Шаардлагагүй.	12	15.4
Нийт		78	100

**Асуулт 2. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт хохирлын хэмжээг тусгаж өгөх шаардлагатай юу?**

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Шаардлагатай.	69	88.5
2	Шаардлагагүй.	9	11.5
Нийт		78	100

**Асуулт 3. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн хүн тэр дундаа гэмт хэргийн улмаас бага хэмжээний хохирол бусдад учруулсан тохиолдолд оногдуулах ялын хэмжээ гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанарт тохирч байгаа эсэх?**

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Тийм	4	5.1
2	Үгүй	45	57.7
3	Ялын төрлийг нэмж, сонголттой болгосноор тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанараас хамааруулан тохирох ялыг оногдуулах боломжтой.	29	37.2
Нийт		78	100

**Асуулт 4. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт ялын төрлийг нэмэх шаардлагатай юу?**

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Шаардлагатай.	55	70.5
2	Шаардлагагүй.	23	29.5
Нийт		78	100

**Асуулт 5. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж бусдад бага хэмжээний хохирол учруулсан тохиолдолд тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанарт тохируулан Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар тухайн үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй байх боломжтой юу?**

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Боломжтой. Тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанараас хамааруулан гэмт хэрэгт тооцохгүй байх боломжтой.	36	46.1
2	Боломжгүй. Учир нь хууль тогтоогч 17.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэгт энэхүү гэмт хэрэгт хохирол шаардахгүй байхаар тодорхой байдлаар тусгасан.	42	53.8
Нийт		78	100

**Асуулт 6. Та Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж бага хэмжээний хохирол бусдад учруулсан хэрэгт Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн гэмт хэрэгт тооцохгүй байдлаар хэрэг шийдвэрлэсэн тохиолдол байгаа эсэх.**

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Тийм	25	32.1
2	Үгүй	53	67.9
Нийт		78	100

**Асуулт 7. Дээрхээс гадна Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийг практикт хэрэгжүүлэхэд тулгамдаж буй нөхцөл байдал байвал дурдана уу.**

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Хариулсан	44	56.4
2	Хариулаагүй	34	43.6
Нийт		78	100

**Асуулт 8. Танд Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлтэй холбоотой засаж сайжруулах ямар санал байна вэ?**



№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Хариулсан	50	64.1
2	Хариулаагүй	28	35.9
Нийт		78	100



## Санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан хэргүүд

Д/Д	Шүүхийн шийдвэрийн нэр	Шүүгдэгч, нас	Хохирлын хэмжээ	Хэргийг шийдвэрлэсэн байдал
1	Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн №107 дугаар тогтоол	Н.Б, 43 настай	151,000	2 жил хорих ял
2	Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн №0231 дугаар тогтоол	М.Б, С.Н нас нь тодорхойгүй	272,100	М.Б- 2 жил хорих ял С.Н- 1 жил хорих ял
3	Дундговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн №64 дүгээр тогтоол	Л.Э, 31 настай	120,000	1 жил хорих ял
4	Сэлэнгэ аймаг Мандал сум дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн №00120 дугаар тогтоол	А.А, 41 настай	160,000	1 жил 1 хоног хорих ял
5	Сэлэнгэ аймаг Мандал сум дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн №00149 дүгээр тогтоол	Б.Э, 34 настай Б.М, 31 настай	114,500	Тус тус 1 жилийн хорих ял
6	Сэлэнгэ аймаг Сайхан сум дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн №02 дугаар тогтоол	Б.О 33 настай	20,000	2 жил хорих ял
7	Хэнтий аймаг Бор-Өндөр сум дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн №58 дугаар тогтоол	Х.Д, өсвөр нас	220,000	1 жил хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ
8	Говьсүмбэр аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн №2019/ШЦТ/03 дугаар тогтоол	Ц.Г, 35 настай	170,000	2 жил хорих ял
9	Дархан-Уул аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн	О.Г, 22 настай	240,000	2 жил хорих ял

	2018 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн №401 дүгээр тогтоол			
10	Өвөрхангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн №194 дүгээр тогтоол	Л.Н, Нас тодорхойгүй	280,000	1 жил хорих ял
11	Сэлэнгэ аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн №203 дугаар тогтоол	Б.Гантулга, 47 настай	100,000	1 жил 2 сар хорих ял
12	Сэлэнгэ аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн №235 дугаар тогтоол	А.Мөнхбат, 30 настай	50,000	1 жил хорих ял
13	Увс аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн №05 дугаар тогтоол	Э.Б, 18 настай	256,000	1 жил хорих ял
14	Хөвсгөл аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн №00344 дүгээр тогтоол	Н.Л, Д.Б нас нь тодорхойгүй	182,000	1 жил хорих ял
15	Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн №873 дугаар тогтоол	Ц.Х, 43 настай	291,500	2 жил хорих ял
16	Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн №887 дугаар тогтоол	Т.Т, 25 настай	300,000	2 жил хорих ял
17	Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн №79 дүгээр тогтоол	Н.З, 34 настай	Өнгөлгөөний дрилл 2 ширхэг	2 жил хорих ял
18	Хан-Уул дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн №11 дүгээр тогтоол	Б.М, 51 настай	100,000	2 жил 1 сар хорих ял
19	Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн №23 дугаар тогтоол	С.Б, 41 настай	150,000	1 жил 1 сар хорих ял

20	Дорнод аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн №16 дугаар тогтоол	Б.Э, 26 настай	240,000	1 жил хорих ял
21	Хөвсгөл аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн №00286 дугаар тогтоол	Х.М,	152,000	1 жил 1 сар хорих ял
22	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн №110 дугаар тогтоол	Л.Б,	51,250	1 жил хорих ял
23	Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн №389 дүгээр тогтоол	З.Б, 27 настай	160,000	1 жил хорих ял
24	Дорнод аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн №2018/ШЦТ/324 дүгээр тогтоол	Д.М,	140,000	1 жил хорих ял
25	Хөвсгөл аймаг дахь сум дундын шүүхийн 2018 оны 11 дугаар сарын 21-ний өдрийн №00333 дугаар тогтоол	С.Б	275,500	1 жил хорих ял
26	Өвөрхангай аймаг Хархорин сум дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн №2018/ШЦТ/84 дүгээр тогтоол	Д.Т, 25 настай	177,300	1 жил хорих ял
27	Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн №806 дугаар тогтоол	Д.А, 46 настай	280,680	1 жил 5 сар хорих ял